



ХЭНТИЙ АЙМАГ  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/07

Бор-Өндөр

Архивын баримт нягтлан шалгах  
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/100 дугаар тушаал “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, хадгалах хугацааг тогтоох, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

А.Өлзийсүрэн

Бэлчээр, газар тариалангийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Солонго

Архив бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд:

Д.Халиунаа

У.Дөлгөөн-Учрал

Ц.Баттуяа

Уурхайчин 4 дүгээр багийн Зохион байгуулагч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагч

Сангууд хариуцсан нягтлан бодогч

2. Байгууллагын үйл ажиллагаа, баримтын онцлогт тохирсон архивын дүрмийг боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг баримт нягтлан шалгах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ